# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр Дугаар 07/43 Булган

Сумын бэлчээрийн эрсдэлийн
менежментийн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 52 дугаар зүйлийн 52.1.2, 52.1.4, 52.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын бэлчээрийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийн явц үр дүнг 12 дугаар сард сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Идэрмөнх)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бужмаа)-д даалгасугай.

ДАРГА Ж.ДОЛООН-ОД

0721017

D:\Togtool\togtool 2022.docx

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 07 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 30 ний өдрийн 07\43 дугаар тогтоолын хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН БЭЛЧЭЭРИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| д/д | Бэлчээрийн менежментийг сайжруулах талаар хийх ажлын зорилго, агуулга | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах эзэн | Үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | **1. Эрхзүйн шийдвэр гаргах түвшинд:** | | | | |
| 1 | Бэлчээрийг зөв зохистой ашиглуулах талаар захирамж гаргаж мөрдөх | Сумын Засаг даргын захирамж гаргах<br>1,2,3,4 багийн иргэдэд захирамжийг мөрдүүлэх | 2022 ондоо | Бэлчээрийн мэргэжилтэн, Сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар, Газрын даамал | Бэлчээрийн маргааныг зохицуулах эрхзүйн үндэс тавигдана |
| 2 | Өвөлжөө хаваржааны байршлаар нь бэлчээр ашиглалтын хэсгүүдийг байгуулж БИНХ-аар хэлэлцүүлэн батлуулах | ИТХ,БИНХ | 2022 ондоо | ИТХ , Бэлчээр хариуцсан мэргэжилтэн | 4 улирлын бэлчээрийн зааг тогтоох |
| 3 | Бэлчээрийн даац хэтэрсэн нөхцөлд сум дундын ашиглалттай газарт отор нүүдэл хийлгэх гэрээ байгуулж зөвшилцөх | Гэрээ хийх | 2022ондоо | Сумын засаг дарга, газрын даамал, багийн засаг дарга нар | Дээрх бүлгийн бэлчээрийн даац зохицуулагдсан байна. |
| 4 | Бэлчээрийн нутагт байгаа уст цэг, булаг шанд булгын эх хамгаалах. | Булгын эх хамгаалагдсан байна | 2022 ондоо | Бэлчээр хариуцсан мэргэжилтэн , Багийн Засаг дарга нар | Булгийн эх хамгаалснаар багийн иргэд малчдын усан хангамжийн тоо нэмэгдэнэ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| 5 | Өөрийн хөрөнгөөр худаг гаргасан малчид иргэдийн урамшуулах | Шинээр худаг гаргасан иргэдийг урамшуулах | 2022 ондоо | Бэлчээрийн мэргэжилтэн, Сумын Засаг дарга | Худгийн тоо нэмэгдэнэ. |
| 6 | Малчдын МАА-н материаллаг баазыг бэхжүүлэх эрсдлээс хамгаалах | Малчдын өвөлжөө хаваржааг гэрчилгээжүүлэх | 2022 ондоо | Бэлчээрийн мэргэжилтэн Сумын багийн Засаг дарга нар газрын даамал | Малчид өөрсдийгөө эрсдлээс хамгаалсан байна. Гэрчилгээтэй болсон байна. |
| | | Эрсдлээс хамгаалах зорилгоор малчин өрх бүрийг өвс тэжээл, худаг ус, хашаа хороог, шинээр барих засах | | | |
| 7 | Ашиглагдахгүй байгаа бэлчээрийг ашиглах, эзэмшүүлэх , бэлчээрийн судалгааг нарийвчлан гаргах | Шинээр уст цэг тогтоож худаг гаргах | Жилдээ | Сумын Засаг дарга Бэлчээр хариуцсан мэргэжилтэн , Багийн Засаг дарга нар | Бэлчээрийг отор нүүдлийн системээр ашиглах шинэ арга ажиллагаа нэвтрэх эхлэл тавигдаж, сумын бэлчээрийн ачаалал тэнцвэржинэ. Бэлчээр дахь усан хангамжийн тоо нэмэгдэнэ. |
| | | Хашаа хороо шинээр барих | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Фотомониторингийн аргаар бэлчээрийн даац, ургац бүрхэцийг тодорхойлох үр дүнг малчид, олон нийтэд хүргэх мэдээллэх | Мал аж ахуйг эрсдлээс хамгаалах зорилгоор даац тогтоох | 8-11 сард | Сумын засаг дарга, Багийн засаг дарга газрын даамал | 4 багийн бэлчээрийн даац тогтоогдсон байна. |
| 9 | Бэлчээр ашиглалтыг сайжруулах малчдын бүлгэм байгуулах | Бэлчээрийн олон талт асуудлыг шийдвэрлэх | Жилдээ | Багийн Засаг дарга нар Бэлчээр хариуцсан мэргэжилтэн. Газрын даамал | Малчдын бүлгийн тоо нэмэгдэнэ |
| **2.Сургалт сурталчилгааг эрчимжүүлж мэдлэгт суурилсан менежментийг хэрэгжүүлэх талаар** | | | | | |
| 10 | Бэлчээрийн менежментийг сайжруулах, ашиглуулах талаар малчдад сургалт сурталчилгаа хийх | Сургалт малчдад хийнэ. | 2022ондоо | Сумын засаг дарга, бэлчээр хариуцсан мэргэжилтэн | Бэлчээрийг зөв хувиартай ашиглана |
| 11 | Бэлчээрийн даац ашиглалтыг улирал бүрээр тодорхойлох чадавхийг малчидад эзэмшүүлэх сургалтыг тогтмолжуулах | Баг тус бүр дээр сургалтыг явуулна. | Жилдээ | Сумын засаг дарга, газрын даамал, бэлчээр хариуцсан мэргэжилтэн, цаг уурч. төслийн нарийн бичиг | Малчид өөрсдөө бэлчээрийнхээ даацыг бие даан тогтоож, данс бүртгэл хөтөлдөг болно. Бэлчээрийн чанарын өөрчлөлт тод харагддаг болно. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Малчдын бүлэг хоршоо байгуулах | Бүлэг хоршооны хэмжээнд бэлчээрийг хувиартай эзэмшүүлэх | 2022 онд | Сумын засаг дарга, Сумын Засаг даргын орлогч, Бэлчээрийн мэргэжилтэн, | Бэлчээрийг зөв хуваарьтай ашиглаж сурсан байна. Хоршооны тоо нэмэгдсэн байна |
| | | Тариалан эрхлүүлэх | | | Тэжээлийн нөөц бэлчээртэй болно. |
| | | Бэлчээр хашиж хамгаалах | | | |